



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/105/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цогбаяр  
Утас: 261663 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn  
Ахлах аудитор: Б.Ариунжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn  
Аудитор: Г.Өсөхжаргал  
Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn

Улаанбаатар хот  
2025 он

## Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	16
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	17
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	18
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	19
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	19
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	21
3.5.3 Нэмэлт төсөв.....	22
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	22
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	23
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	23
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	23
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	24
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	24
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	25
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	25
4.5.1 Завсрын аудитын талаар.....	25
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	26
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	26
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	27
5.1 Албан шаардлага .....	27
5.3 Зөвлөмж .....	30
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	32

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
СНАГ	Санхүү, нийцлийн аудитын газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУ	Олон улс
ОУБ	Олон улсын байгууллага
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь, хүний орлогын албан татвар
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.МӨНХЗУЛ ТАНАА

2025.02.05 № 07/757  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Нэг төрлийн бараа ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоогүй 23 хуулийн этгээдтэй нийт 591,972.3 мянган төгрөгийн ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийж, гэрээ байгуулсан;
- Гэрээний хэрэгжилт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангаагүй 413,300.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгасан;
- Гадаад, дотоод албан томилолтын 127,084.1 мянган төгрөгийг бараа ажил үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлэх болон бараа үйлчилгээний бусад зардлаас ангилал зөрчиж зарцуулсан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын ангиллыг 274,999.6 мянган төгрөгөөр буруу тайлагнасан;
- Санхүүгийн тайланд тусгагдсан биет бус хөрөнгийн дүн өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн дүнгээс 287,835.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Z:\Yawsan\_Bichig\2025\0225 SNAG-93.Docx

1525000395

- Сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулахад нийт 620,489.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр шаардлагагүй зардалд 72 хувь буюу 445,906.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "ангилал", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

НҮБ-ын Хүн амын сангаас Монгол Улсад 2023-2027 оны хэрэгжүүлэх 5 жилийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын хүүхдийн сангаас 249,725.7 мянган төгрөг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 160,232.2 мянган төгрөг, ДЭМБ-ийн төлөөлөгчийн газраас 97,898.5 мянган төгрөг, засгийн газрын нөөц сангаас 568,650.8 мянган төгрөг, Лоринет ТББ-аас 56,100.0 мянган төгрөг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 7,205.6 мянган төгрөг, сангийн яамнаас 803,887.9 мянган төгрөг нийт 1,943,700.9 мянган төгрөгийн хандив хүлээн авснаас Олон улсын Найрамдал зуслангийн засвар шинэчлэлд 1,364,028.8 мянган төгрөг, бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих гишүүдийн сургалт зохион байгуулах зардалд 29,089.7 мянган төгрөг, хуулийн хэлэлцүүлгийн зардалд 49,492.1 мянган төгрөг, Ази номхон далайн хуралд оролцох зардалд 7,525.0 мянган төгрөг, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн чадавхжуулах сургалтын зардалд 76,426.1 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын зардалд 26,399.5 мянган төгрөг, салбарын хяналтын улсын байцаагчдын сургалтын зардалд 59,829.0 мянган төгрөг, бусад зардалд 151,111.9 мянган төгрөг, гүйцэтгэлээр нийт 1,816,418.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 52,516.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан малчин, туслах малчны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувь, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцгийн нийгмийн даатгалын шимтгэлийг 100 хувь улсын төсвөөс сар бүр төлөхөөр батлагдаж, яамны 2024 оны батлагдсан төсвөөс дээрх 2 төрлийн нийгмийн даатгалын шимтгэлд 34,809,663.9 мянган төгрөгийг олгожээ.

## Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2023 оны 352, 378 дугаар тогтоолуудаар Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл Ажлын албыг байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын /хуучин нэрээр/ эрхлэх асуудлын хүрээний байгууллагын харьяа агентлаг "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил"-ийн газрын дэргэдэх "Залуучуудын хөгжил"-ийн газрыг тус яамны зохион байгуулалтын бүтцэд нэмж оруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>496,193,856.82</b>	<b>424,680,885.62</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>35,386,321.62</b>	<b>52,086,321.62</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	35,386,321.62	52,086,321.62
31210	Төгрөг	35,386,321.62	52,086,321.62
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31217	Төрийн сангийн харилцах	35,386,321.62	52,086,321.62
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>12,720,438.00</b>	<b>57,416,595.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,820,438.00	52,516,595.00
33500	Бусад авлага	4,900,000.00	4,900,000.00
33510	Байгууллагаас авах авлага	4,900,000.00	4,900,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>12,600,000.00</b>	-
34600	Урьдчилж гарсан зардал	12,600,000.00	-
34700	Бусад урьдчилгаа	-	-
34710	Урьдчилгаа тооцоо	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>218,471,247.20</b>	<b>98,162,119.00</b>
35400	Хангамжийн материал	218,471,247.20	98,162,119.00
35410	Бичиг хэргийн материал	119,036,230.00	8,888,300.00
35420	Аж ахуйн материал	28,912,740.84	23,331,680.00
35430	Сэлбэг хэрэгсэл	12,363,500.00	15,175,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	58,158,776.36	49,767,139.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>217,015,850.00</b>	<b>217,015,850.00</b>
36900	БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө	217,015,850.00	217,015,850.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>5,035,106,659.08</b>	<b>4,967,944,946.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,035,106,659.08</b>	<b>4,967,944,946.81</b>
39200	Биет хөрөнгө	4,233,036,169.08	3,928,730,467.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,728,716,115.00	4,003,962,236.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(466,089,514.20)	(559,307,417.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	384,833,000.00	360,833,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(209,596,989.03)	(251,858,222.38)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,096,914,758.64	1,731,255,793.64
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(1,533,956,929.12)	(1,723,478,316.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	534,055,528.00	623,618,727.50
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(363,116,168.17)	(317,571,701.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,665,861.00	62,665,861.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(2,133,293.04)	(2,133,293.04)
39217	Номын фонд	743,800.00	743,800.00
39300	Биет бус хөрөнгө	802,070,490.00	1,039,214,478.95
39301	Програм хангамж	2,196,658,219.04	1,018,804,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(2,164,095,069.04)	(207,332,911.05)
39303	Бусад биет бус хөрөнгө	769,507,340.00	227,742,890.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>5,531,300,515.90</b>	<b>5,392,625,832.43</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
41300	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41311	Цалингийн өглөг	-	-
41312	НДШ-ийн өглөг	-	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	-

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>5,531,300,515.90</b>	<b>5,392,625,832.43</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,531,300,515.90	5,392,625,832.43
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	769,507,340.00	769,507,340.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	769,507,340.00	769,507,340.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,314,723,777.94	4,176,049,094.47
51210	Өмнөх үеийн үр дүн	5,160,506,967.49	4,314,723,777.94
51220	Тайлант үеийн үр дүн	(845,783,189.55)	(138,674,683.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,069,397.96	447,069,397.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>5,531,300,515.90</b>	<b>5,392,625,832.43</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,848,837,759.40</b>	<b>59,924,588,154.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>226,469,213.71</b>	<b>2,044,514,664.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	226,469,213.71	2,044,514,664.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,363,025.00	102,160,626.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	38,363,025.00	102,160,626.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	187,766,188.71	1,942,354,038.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	340,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,622,368,545.69</b>	<b>57,880,073,490.00</b>
1310	Улсын төсвөөс	12,408,965,565.67	56,018,958,617.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,408,965,565.67	56,018,958,617.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,213,402,980.02	1,861,114,873.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,117,749,980.02	488,576,071.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	9,688,000.00	1,372,538,802.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,965,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>15,598,270,034.93</b>	<b>57,926,001,833.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,598,270,034.93</b>	<b>57,926,001,833.48</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,793,237,812.41	12,829,136,296.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,239,534,210.79	6,164,342,622.33
210101	Үндсэн цалин	2,825,960,017.15	3,082,814,863.63
210102	Нэмэгдэл	777,742,547.77	1,351,430,774.45
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	475,278,824.68	696,770,495.24
210104	Урамшуулал	905,135,679.19	917,193,689.01
210105	Гэрээт ажлын цалин	255,417,142.00	116,132,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	533,912,579.15	683,636,333.84
210201	Тэтгэврийн даатгал	341,916,175.06	469,297,905.40
210202	Тэтгэмжийн даатгал	72,907,351.18	55,650,148.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,349,017.38	27,664,505.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,912,038.91	25,942,860.58
210205	Эрүүл мэндийн даатгал	73,827,996.62	105,080,914.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,225,150.00	183,027,150.00
210301	Гэрэл, цахилгаан	78,718,900.00	94,881,200.00
210302	Түлш, халаалт	50,494,600.00	57,467,340.00
210303	Цэвэр, бохир ус	17,720,400.00	20,814,410.00
210304	Байрны түрээс	35,291,250.00	9,864,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	373,592,447.17	506,489,216.07
210401	Бичиг хэрэг	109,958,436.50	212,673,884.00
210402	Тээвэр, шатахуун	64,825,368.65	24,498,516.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,141,772.91	50,388,438.37
210404	Ном, хэвлэл	37,770,620.00	92,899,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	111,396,249.11	126,029,377.70
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,500,000.00	-
2105	Нормативт зардал	295,548,525.00	78,888,377.37
210502	Хоол, хүнс	295,548,525.00	49,506,378.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	29,381,999.37
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	305,427,370.00	40,671,948.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	256,539,750.00	3,755,500.00
210604	Урсгал засвар	48,887,620.00	36,916,448.00
2107	Томиллолт, зочны зардал	419,089,427.14	385,467,987.62
210701	Гадаад албан томилолт	49,134,000.00	198,085,137.62
210702	Дотоод албан томилолт	369,955,427.14	187,382,850.00

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,793,779,491.00	1,542,823,465.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,755,046,521.00	1,495,940,184.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,688,860.00	3,848,382.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370,824.00	399,324.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	98,700.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,392,700.00	36,759,257.00
210807	Газрын төлбөр	12,181,886.00	5,799,318.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,650,128,612.16	3,243,789,195.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	343,172,385.88	1,124,559,579.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	247,353,487.30	443,691,719.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	1,059,602,738.98	1,675,537,897.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,805,032,222.52	45,096,865,537.48
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,878,692,256.56	716,013,248.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,876,607,256.56	716,013,248.14
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,085,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,842,135.00	34,961,793,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	34,809,663,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,350,000.00	13,350,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,591,426.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,900,709.00	138,780,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,599,978,905.67	9,242,897,636.12
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	180,518,925.29	176,160,753.22
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>96,350,914.02</b>	<b>2,137,261,004.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(749,432,275.53)</b>	<b>1,998,586,320.52</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>96,350,914.02</b>	<b>2,137,261,004.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	96,350,914.02	2,137,261,004.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	35,350,914.02	5,351,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	742,064,400.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн шилжүүлэх зорилготой хөрөнгө	61,000,000.00	1,389,845,604.00
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>(845,783,189.55)</b>	<b>(138,674,683.48)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>5,016,589,276.75</b>	<b>6,233,166,014.71</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(143,917,690.74)	(143,917,690.74)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	769,507,340.00	447,069,397.96	4,872,671,586.01	6,089,248,323.97
Тайлант үеийн үр дүн			(845,783,189.55)	(845,783,189.55)
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>4,314,723,777.94</b>	<b>5,531,300,515.90</b>
<b>2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>4,314,723,777.94</b>	<b>5,531,300,515.90</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	769,507,340.00	447,069,397.96	4,314,723,777.94	5,531,300,515.90
Тайлант үеийн үр дүн	-	-	(138,674,683.47)	(138,674,683.47)
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>769,507,340.00</b>	<b>447,069,397.96</b>	<b>4,176,049,094.47</b>	<b>5,392,625,832.43</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,728,981,570.69</b>	<b>57,990,054,554.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,363,025.00</b>	<b>102,160,626.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	38,363,025.00	102,160,626.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,363,025.00	102,160,626.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	38,363,025.00	102,160,626.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,690,618,545.69</b>	<b>57,887,893,928.00</b>
1310	Улсын төсвөөс	12,408,965,565.67	56,018,958,617.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,408,965,565.67	56,018,958,617.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,281,652,980.02</b>	<b>1,868,935,311.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,122,999,980.02	496,396,509.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	9,688,000.00	1,372,538,802.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	148,965,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>14,632,690,201.69</b>	<b>57,559,917,006.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,632,690,201.69</b>	<b>57,559,917,006.50</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,819,837,541.17	12,410,534,874.02
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,074,561,321.37	6,100,094,389.04
210101	Үндсэн цалин	2,516,234,062.88	2,514,730,499.69
210102	Нэмэгдэл	982,070,065.62	2,111,658,300.34
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	437,219,323.70	603,563,700.00
210104	Урамшуулал	871,020,727.17	766,609,089.01
210105	Гэрээт ажлын цалин	268,017,142.00	103,532,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	578,968,894.17	682,051,266.74
210201	Тэтгэврийн даатгал	404,581,374.22	469,971,070.95
210202	Тэтгэмжийн даатгал	44,070,967.83	54,986,770.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,186,374.25	27,239,402.47
210204	Ажилгүйдлийн даатгал	8,648,252.56	25,836,584.95
210205	Эрүүл мэндийн даатгал	86,481,925.31	104,017,437.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,225,150.00	183,027,150.00
210301	Гэрэл, цахилгаан	78,718,900.00	94,881,200.00
210302	Түлш, халаалт	50,494,600.00	57,467,340.00
210303	Цэвэр, бохир ус	17,720,400.00	20,814,410.00
210304	Байрны түрээс	35,291,250.00	9,864,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	354,279,554.91	245,654,768.37
210401	Бичиг хэрэг	89,566,390.00	89,297,224.00
210402	Тээвэр, шатахуун	59,530,022.00	29,568,516.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,141,772.91	50,388,438.37
210404	Ном, хэвлэл	39,096,000.00	2,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,945,370.00	73,700,590.00
2105	Нормативт зардал	295,548,525.00	49,506,378.00
210502	Хоол, хүнс	295,548,525.00	49,506,378.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	309,175,370.00	97,859,519.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	260,287,750.00	23,879,570.00
210604	Урсгал засвар	48,887,620.00	73,979,949.50
2107	Томилолт, зочны зардал	423,564,427.14	373,869,987.62
210701	Гадаад албан томилолт	49,134,000.00	196,857,137.62
210702	Дотоод албан томилолт	374,430,427.14	177,012,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,032,810,425.40	1,636,366,765.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,992,887,455.40	1,589,303,484.38
210803	Даатгалын үйлчилгээ	5,688,860.00	3,848,382.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370,824.00	399,324.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	98,700.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,582,700.00	36,939,257.00
210807	Газрын төлбөр	12,181,886.00	5,799,318.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	568,703,873.18	3,042,104,649.37

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	321,237,385.88	2,567,077,880.37
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	247,466,487.30	475,026,769.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,812,852,660.52	45,149,382,132.48
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,886,512,694.56	768,529,843.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,876,607,256.56	716,013,248.14
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,905,438.00	52,516,595.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,842,135.00	34,961,793,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	34,809,663,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,350,000.00	13,350,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,591,426.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,900,709.00	138,780,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,599,978,905.67	9,242,897,636.12
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	180,518,925.29	176,160,753.22
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>96,291,369.00</b>	<b>430,137,547.50</b>
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>76,410,700.00</b>	<b>413,437,547.50</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>76,410,700.00</b>	<b>413,437,547.50</b>
222	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	61,000,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	61,000,000.00	-
223	БУСАД ХӨРӨНГӨ	15,410,700.00	413,437,547.50
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,410,700.00	413,437,547.50
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(76,410,700.00)</b>	<b>(413,437,547.50)</b>
9	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
10	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>19,880,669.00</b>	<b>16,700,000.00</b>
14	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>35,386,321.62</b>
15	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>19,880,669.00</b>	<b>52,086,321.62</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>56,718,017,800.00</b>	<b>55,355,105,994.86</b>	<b>1,362,911,805.14</b>	<b>97.6</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>56,718,017,800.00</b>	<b>55,355,105,994.86</b>	<b>1,362,911,805.14</b>	<b>97.6</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>12,165,294,100.00</b>	<b>10,993,753,705.52</b>	<b>1,171,540,394.48</b>	<b>90.4</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>6,152,763,700.00</b>	<b>5,996,561,589.04</b>	<b>156,202,110.96</b>	<b>97.5</b>
210101	Үндсэн цалин	2,602,964,000.00	2,514,730,499.69	88,233,500.31	96.6
210102	Нэмэгдэл	2,171,458,200.00	2,111,658,300.34	59,799,899.66	97.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	603,563,700.00	603,563,700.00	-	100.0
210104	Урамшуулал	774,777,800.00	766,609,089.01	8,168,710.99	98.9
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>709,775,600.00</b>	<b>682,051,266.74</b>	<b>27,724,333.26</b>	<b>96.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	482,647,400.00	469,971,070.95	12,676,329.05	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	56,782,100.00	54,986,770.53	1,795,329.47	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,391,000.00	27,239,402.47	1,151,597.53	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	28,391,000.00	25,836,584.95	2,554,415.05	91.0
210205	Эрүүл мэндийн даатгал	113,564,100.00	104,017,437.84	9,546,662.16	91.6
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>175,043,600.00</b>	<b>173,162,950.00</b>	<b>1,880,650.00</b>	<b>98.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	94,881,200.00	94,881,200.00	-	100.0
210302	Түлш, халаалт	59,345,200.00	57,467,340.00	1,877,860.00	96.8
210303	Цэвэр, бохир ус	20,817,200.00	20,814,410.00	2,790.00	100.0
210304	Байрны түрээс	-	-	-	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>215,959,900.00</b>	<b>215,958,958.37</b>	<b>941.63</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	83,252,400.00	82,804,030.00	448,370.00	99.5
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,606,100.00	50,388,438.37	12,217,661.63	80.5
210404	Ном, хэвлэл	-	-	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69,101,400.00	81,766,490.00	(12,665,090.00)	118.3
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	-
210502	Хоол, хүнс	-	-	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	-	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>532,549,700.00</b>	<b>483,331,167.00</b>	<b>49,218,533.00</b>	<b>90.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	77,113,400.00	61,875,185.00	15,238,215.00	80.2
210602	Тавилга	-	-	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	-	-
210604	Урсгал засвар	455,436,300.00	421,455,982.00	33,980,318.00	92.5

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>344,873,000.00</b>	<b>277,637,173.62</b>	<b>67,235,826.38</b>	<b>80.5</b>
210701	Гадаад албан томилолт	220,200,000.00	196,857,137.62	23,342,862.38	89.4
210702	Дотоод албан томилолт	124,673,000.00	80,780,036.00	43,892,964.00	64.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,588,623,300.00</b>	<b>1,656,266,765.38</b>	<b>932,356,534.62</b>	<b>64.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,534,952,000.00	1,609,203,484.38	925,748,515.62	63.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-	
210803	Даатгалын үйлчилгээ	8,669,700.00	3,848,382.00	4,821,318.00	44.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,800.00	399,324.00	2,476.00	99.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	96,800.00	77,000.00	19,800.00	79.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,972,600.00	36,939,257.00	33,343.00	99.9
210807	Газрын төлбөр	7,530,400.00	5,799,318.00	1,731,082.00	77.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			-	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			-	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,445,705,300.00</b>	<b>1,508,783,835.37</b>	<b>(63,078,535.37)</b>	<b>104.4</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,095,895,300.00	1,184,739,078.37	(88,843,778.37)	108.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	349,810,000.00	324,044,757.00	25,765,243.00	92.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,552,723,700.00</b>	<b>44,361,352,289.34</b>	<b>191,371,410.66</b>	<b>99.6</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>9,420,874,000.00</b>	<b>9,419,058,389.34</b>	<b>1,815,610.66</b>	<b>100.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,243,687,000.00	9,242,897,636.12	789,363.88	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	177,187,000.00	176,160,753.22	1,026,246.78	99.4
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,131,849,700.00</b>	<b>34,942,293,900.00</b>	<b>189,555,800.00</b>	<b>99.5</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	34,809,663,900.00	34,809,663,900.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,350,000.00	13,350,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	184,102,200.00	-	184,102,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	124,733,600.00	119,280,000.00	5,453,600.00	95.6
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>56,718,017,800.00</b>	<b>55,355,105,994.86</b>	<b>1,362,911,805.14</b>	<b>97.6</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>56,718,017,800.00</b>	<b>55,355,105,994.86</b>	<b>1,362,911,805.14</b>	<b>97.6</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	<b>56,718,017,800.00</b>	<b>55,355,105,994.86</b>	<b>1,362,911,805.14</b>	<b>97.6</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>35,386,321.62</b>	<b>(35,386,321.62)</b>	

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	52,086,321.62	(52,086,321.62)	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	-	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага			-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>144</b>	<b>144</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	24	24	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	120	120	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	
620004	Гэрээт ажилтан	-	-	-	



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,868,935,311.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,816,418,716.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,816,418,716.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	103,532,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	103,532,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	9,864,200.00
210304	Байрны түрээс	-	9,864,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	37,761,710.00
210401	Бичиг хэрэг	-	6,493,194.00
210402	Тээвэр, шатахуун	-	28,568,516.00
210404	Ном, хэвлэл	-	2,700,000.00
2105	Нормативт зардал	-	45,506,378.00
210502	Хоол, хүнс	-	45,506,378.00
2107	Томилолт, зочны зардал	-	96,232,814.00
210702	Дотоод албан томилолт	-	96,232,814.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,523,520,814.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,372,538,802.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	150,982,012.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	52,516,595.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	52,516,595.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>1,868,935,311.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,868,935,311.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	-	496,396,509.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	1,372,538,802.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
12000	Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь гэр бүл, хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан уялдаатай цогц бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулахад судалгаа, шинжилгээ, бодлогын удирдамжаар хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны үйл ажиллагаанд хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж сурталчлах, сургалт зохион байгуулах;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын бүлгүүдийн хөгжил, оролцоог хангах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбар дундын гэр бүлд ээлтэй цогц бодлого боловсруулж, хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих;
- Эрэлтэд нийцсэн хөдөлмөрийн зах зээлийн зөв, оновчтой бодлого боловсруулж гэр бүлд ээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн хууль тогтоомж, цалин хөлсний бодлого зохицуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт болон бусад хамтын ажиллагааг хангах, нийгмийн халамж, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзсан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх;
- Салбарын хууль тогтоомж, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд хяналт тавих;
- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, дүн шинжилгээ хийх;
- Салбарын санхүү, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл, төсөв боловсруулах, батлуулах, хөрөнгө оруулалт, төсвийн шинжилгээ хийх, салбар хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх;
- Салбарын цахим, мэдээллийн технологийг хөгжүүлэх чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, батлуулах, ашиглах, их өгөгдөлд суурилсан бодлогын зөвлөмжөөр хангах, статистикийн мэдээлэл боловсруулах.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Нийгмийн хамгааллын олон улсын хурлыг 2024 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Уг хуралд Азийн хөгжлийн банкны гишүүн орнууд болох Азербайжан, Пакистан, Филиппин, Индонез, Узбекистан зэрэг улсын төлөөллүүд оролцож, харилцан хоорондоо туршлага солилцож ажилласан;
- Засгийн газрын баталсан 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлсэн;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 122 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлсэн;

- “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгээр Ejob-Онлайнаар ажилд зуучлах үйлчилгээг нэвтрүүлсэн;
- Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр Нийгмийн халамжийн үйлчилгээний ehalamj.mn системийг хөгжүүлэхээр системийн хөгжүүлэлтийг хийсэн;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн боловсруулж, стратегийн бодлогын зорилт, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг тодорхойлон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Ахмад настны тухай;
- Гэр бүлийн тухай;
- Хүүхэд хамгааллын тухай;
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай;
- Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль;
- Нийгмийн халамжийн тухай;
- Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай;
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай;
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай;
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын /хуучин нэрээр/ 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/33 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хүрээнд яам, агентлаг, харьяа байгууллага, тусгай сангийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Үндэсний аудитын газар, Сангийн яамнаас хийсэн аудит, хяналт шалгалтын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангах, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөрөнгө оруулалтын явц, үйл ажиллагаа, 4 агентлагийн 2023 он, 2024 оны эхний хагас жилийн төсвийн зарцуулалт, холбогдох хууль, журмын хэрэгжилт үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод аудит, хяналт шалгалтын 8 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж, нийт 949,900.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 126 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2017 онд батлагдсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,674.7 мянган төгрөгөөр буюу 0.03 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	35,386.3	52,086.3	16,700.0
Авлага	12,720.4	57,416.6	44,696.2
Урьдчилгаа	12,600.0	-	(12,600.0)
Бараа материал	218,471.2	98,162.1	(120,309.1)
Эргэлтийн бус хөрөнгө	217,015.9	217,015.9	-
Үндсэн хөрөнгө	5,035,106.7	4,967,944.9	(67,161.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,531,300.5</b>	<b>5,392,625.8</b>	<b>(138,674.7)</b>
Засгийн газрын хувь оролцоо	5,531,300.5	5,392,625.8	(138,674.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,531,300.5</b>	<b>5,392,625.8</b>	<b>(138,674.7)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 52,086.3 мянган төгрөг болж, 16,700.0 мянган төгрөгөөр өссөн нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын 1.2 дахь хэсэг, ХНХС-ын 2022 оны А/59 дүгээр тушаалын дагуу цалингийн нэмэгдлийн хэмнэлтээс 50,000.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэнтэй холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 57,416.6 мянган төгрөг болж, 44,696.2 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 52,516.6 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах шатахууны талоны авлага 17,714.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, авлага дансны өмнөх оны үлдэгдэл 7,820.4 мянган төгрөгийг барагдуулж, хувь хүмүүсээс авах шатахууны талоны 17,714.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой;
- Авлага дансны үлдэгдэлд тайлант онд үүссэн татаас санхүүжилтийн авлага 52,516.6 мянган төгрөг, 2020 онд үүссэн Засгийн газрын мэдээ сонин ХХК-аас авах гэрээт ажлын урьдчилгаа 4,900.0 мянган төгрөг тус тус бүртгэлтэй байна.

- Урьдчилгаа данс үлдэгдэлгүй болж, 12,600.0 мянган төгрөгөөр буурсан нь сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгосонтой холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 98,162.1 мянган төгрөг болж, 120,309.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд худалдан авсан 340,443.7 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуй, сэлбэг хэрэгсэл, түлш, шатахуун, бусад хангамжийн материалаар нэмэгдэж, 460,613.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой;
- Нөөцийн бараа материал дансны үлдэгдэлд эргэлтийн бус хөрөнгөд 217,015.9 мянган төгрөгийн Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд эмнэлгийн зориулалтай барилга байгууламж барих ажлын зураг, төсөл бүртгэлтэй байгаатай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,967,944.9 мянган төгрөг болж, 67,161.7 мянган төгрөгөөр буурсан нь их засварын ажлын зураг 275,246.1 мянган төгрөг, 43,811.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 94,379.6 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан, 100,000.0 мянган төгрөгийн Ландкрузер-200 маркийн авто машины үнэлгээг шинэчлэн тогтоосон, 574,081.3 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 100,626.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, өгөгдлийн сангийн удирдлагын систем 974,000.0 мянган төгрөгийн программ хангамж, ажилчдын зуслангийн газар 176,700.0 мянган төгрөг, хүүхэд хөгжлийн төв барих газар 16,946.8 мянган төгрөг нийт 2,355,791.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 124,000.0 мянган төгрөгийн Ландкрузер-200 маркийн авто машин, 983,552.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 105,442.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,151,853.7 мянган төгрөгийн программ хангамж, 735,411.2 мянган төгрөг, нийт 4,100,259.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,392,625.8 мянган төгрөг болж, 989,700.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүн болон 138,674.4 мянган төгрөгийн газрын хуримтлагдсан элэгдлийг залруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-д заасны дагуу төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 54,523,585.1 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 54,523,585.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг 869,973.2 мянган төгрөгөөр бууруулж, төсвийг 53,653,611.9 мянган төгрөгөөр баталжээ. Батлагдсан төсвийн 64.9 хувь буюу 34,809,663.9 мянган төгрөг эзэлж байгаа нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан зарим<sup>1</sup> нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр улсын төсвөөс олгохоор болсонтой холбоотой байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийт зардлыг 3,064,405.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 56,718,017.8 мянган төгрөгөөр тодотгон батлагдсан байна. Тухайлбал: цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 442,827.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,574,321.0 мянган төгрөг, албан томилолт, зочны зардал 171,168.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

<sup>1</sup> 21.23 Малчин, туслах малчин энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна. 21.22 Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 20 арга хэмжээнд 56,718,017.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 55,355,106.0 мянган төгрөгийн зарцуулж, үлдэгдэл 1,362,911.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 55,355,106.0 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин, хөлсний зардал 156,202.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 27,724.3 мянган төгрөг, байр ашиглалттай тогтмол зардал 1,880.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 49,218.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 932,356.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
<b>Нийт дүн</b>			<b>56,718,017.8</b>	<b>55,355,106.0</b>	<b>1,362,911.8</b>	<b>97.6</b>
1	71901	<b>Нийгмийн даатгал</b>	<b>43,307,328.9</b>	<b>43,307,328.9</b>	-	<b>100.0</b>
1.1	80612	Нийгмийн даатгалын бусад	34,809,663.9	34,809,663.9	-	100.0
1.2	80615	Эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл	8,497,665.0	8,497,665.0	-	100.0
2	71902	<b>Нийгмийн халамж</b>	<b>251,214.0</b>	<b>251,214.0</b>	-	<b>100.0</b>
2.1	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	13,350.0	13,350.0	-	100.0
2.2	80831	Цаатан иргэдийн НДШ	237,864.0	237,864.0	-	100.0
3	71903	<b>Нийгмийн хамгааллын бодлого удирдлага</b>	<b>10,807,140.7</b>	<b>9,917,803.5</b>	<b>889,337.2</b>	<b>91.8</b>
3.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	8,335,415.4	8,008,839.4	326,576.0	96.1
3.2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	147,150.0	103,702.0	43,448.0	70.5
3.3	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	221,460.7	171,254.4	50,206.2	77.3
3.4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	526,048.7	487,491.4	38,557.3	92.7
3.5	80239	Тээврийн үйлчилгээ	103,564.8	80,597.1	22,967.7	77.8
3.6	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	177,187.0	176,160.7	1,026.2	99.4
3.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	308,835.8	119,280.0	189,555.8	38.6
3.8	80824	Цэргийн алба хааж байсан иргэдийн НДШ	508,158.0	507,368.6	789.4	99.8
3.9	81520	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	210,250.0	101,763.2	108,486.8	48.4
3.10	81549	Ахмадын сан	49,250.0	-	49,250.0	-
3.11	81560	Монголын улаан загалмайн нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх	30,785.6	30,785.6	-	100.0
3.12	82614	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа хөтөлбөр	189,034.7	130,560.9	58,473.8	69.1
4	72206	<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал</b>	<b>253,098.0</b>	<b>295,135.5</b>	<b>(42,037.5)</b>	<b>116.6</b>
4.1	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	253,098.0	295,135.5	(42,037.5)	116.6
5	72207	<b>Хүүхдийн хөгжил, хамгаалал</b>	<b>329,700.0</b>	<b>108,859.4</b>	<b>220,840.6</b>	<b>33.0</b>
5.1	80238	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	329,700.0	108,859.4	220,840.6	33.0
6	72208	<b>Ахмад настны хөгжил хамгаалал</b>	<b>231,737.2</b>	<b>186,737.2</b>	<b>45,000.0</b>	<b>80.6</b>
6.1	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	231,737.2	186,737.2	45,000.0	80.6
7	72209	<b>Залуучууд болон оюутнууд</b>	<b>1,260,868.0</b>	<b>1,048,971.5</b>	<b>211,896.5</b>	<b>83.2</b>
8	72212	<b>Гэр бүлийн хөгжил хамгаалал</b>	<b>276,931.0</b>	<b>239,055.9</b>	<b>37,875.1</b>	<b>86.3</b>
8.1	83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд	276,931.0	239,055.9	37,875.1	86.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НҮБ-ын Хүн амын сангаас Монгол Улсад 2023-2027 оны хэрэгжүүлэх 5 жилийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын хүүхдийн сангаас 249,725.7 мянган төгрөг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 160,232.2 мянган төгрөг, ДЭМБ төлөөлөгчийн газраас 97,898.5 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангаас ОУ-ын Найрамдал цогцолборын засвар, шинэчлэлийн ажилд 1,372,538.8 мянган төгрөг, Лоринет ТББ-аас 56,100.0 мянган төгрөг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 7,205.6 мянган төгрөг, нийт 1,943,700.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,868,935.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 52,516.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж Сангийн яамны Төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД төсвийн шууд захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 63,408.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төрлийн ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар баталжээ. Үүнд: шуудангийн үйлчилгээний зардалд 16,106.0 мянган төгрөг, интернэт үйлчилгээний зардалд 14,400.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалын зардалд 18,902.0 мянган төгрөг, тэргүүний ажилтны тэмдгийн зардалд 14,000.0 мянган төгрөг.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө, жагсаалтад өөрчлөлт ороогүй, худалдан авалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн яам, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус яамны үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн зарцуулалт, зардлын эдийн засгийн ангилал, гэрээний хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан.

Аудитыг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/245 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардал 15,694,620.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 235,419.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, тайлант оны нийт зардал 60,063,262.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 600,632.6 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан малчин, туслах малчны нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувь, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцгийн нийгмийн даатгалын шимтгэлийг 100 хувь улсын төсвөөс сар бүр тус тус төлөхөөр батлагдаж, ГБХНХЯ-ны нийт зардал 34,809,663.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Үүнд:

1. "Засгийн газрын цом-2024" спортын арга хэмжээнд оролцох хураамжийн 4,900.0 мянган төгрөгийг яамны мэргэжилтний хувийн харилцах дансанд анхан шатны баримтгүй шилжүүлсэн, мөн байгууллагын албан хаагчдад хүндэтгэл үзүүлэхэд мөнгөн аяга худалдан авахад 5,385.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулахад бэлэг, дурсгалын зүйлд 1,839.0 мянган төгрөг, яамны албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардлаас 747.5 мянган төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны



баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хэмнэлтийн бодлогыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

2. Байгууллагын шилдэг ажилтнаар шалгарсан 18 албан хаагчид /1,933.0-2,171.0 мянган төгрөг хүртэл/ нийт 37,388.0 мянган төгрөгийг зардлын ангилал зөрчин цалингийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", "Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох зардлын ангилал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 4,720,643.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,720,643.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлээгүй албан хаагчид сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, тайлант онд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4,670,383.8 мянган төгрөгийн 35 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно."

Шийдвэрлэсэн нь: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

ГБХНХЯ-ны 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар нийт 594,175.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 293,818.7 мянган төгрөгийн 5 алдааг залруулах, 237,689.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 7 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын ангиллыг 139,846.5 мянган төгрөгөөр буруу тайлагнасан. Үүнд: Гэрээт ажилтны цалин, хөлсний зардлаас 3 хуулийн этгээдэд гэрээт ажлын хөлс 29,250.0 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 7 төрлийн сургалт, хэлэлцүүлэг, ахмад настныг хүлээн авахад 46,781.2 мянган төгрөг, тээвэр, шатахууны зардлаас албан томилолтоор ажилласан 124 ажилтны замын зардлын 14,764.0 мянган төгрөг, нормын хувцас хэрэглэлийн зардлаас ахмадуудад монгол дээлийн 29,449.3 мянган төгрөг, бичиг хэргийн зардлаас ХНХ-ын салбарын 2020-2023 онд хэрэгжүүлсэн ажил, бодлого сурталчлах сонины зардалд 19,602.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, зардлын ангилал зөрчсөн;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангахгүй 7,841.4 мянган төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгсэлд тушаал шийдвэр, Өмч хамгаалах байнгын зөвлөл болон техникийн комиссын дүгнэлтгүй нийт 7,642.2 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн;
- Нэг төрлийн ажил, үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2 байгууллагатай нийт 59,800 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийж, гэрээ байгуулсан нь Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнээс хэтэрсэн;
- Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчиж байгууллагын албан хаагчдад хүндэтгэл үзүүлэхэд 6,304.5 мянган төгрөгөөр мөнгөн аяга, оролт зэрэг бэлэг дурсгалын шинжтэй хөрөнгө бэлтгэсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж яамны Төрийн нарийн бичгийн дарга нь "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-тай эрх бүхий албан тушаалтанд суудлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, шатахууны зардалд 16,255.3 мянган төгрөгийг зарцуулсан зөрчлийг арилгаагүй тул санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэр өгсөн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 948,538.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг биелүүлж, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шилэн данстай холбоотой өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, биелэлт 90.0 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	392,306.5	4	392,306.5	100.0
Зөвлөмж	5	556,232.2	4	556,232.0	80.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>948,538.7</b>	<b>8</b>	<b>948,538.7</b>	<b>90.0</b>

Өмнөх аудитаар өгсөн шилэн данстай холбоотой зөрчлийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Азийн хөгжлийн банкнаас нийт 521,000.0 мянган төгрөгийн санхүүжилттэй Нийгмийн халамжийн шинэчлэлд тусгасан зорилтот өрхийг чадавжуулах халамжийн үйлчилгээний загвар тодорхойлох хөтөлбөрийг 2022 оны 7 дугаар сараас 2025 оны 8 дугаар сарыг дуустал буюу 36 сарын хугацаатай, хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрагдсан 1,259 зорилтот өрхийн нийгмийн болон санхүүгийн чадавх, нийгмийн оролцоог сайжруулсан, дээрх өрхүүдэд олгосон 11 төрлийн тоног, төхөөрөмж, хөрөнгө ашиглалтын байдалд хийсэн үнэлгээ, арга хэмжээний хүрсэн үр дүн, хэрэгжилтэд түүврийн горим сорил хэрэгжүүлсэн хэдий ч цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,590,693.4 мянган төгрөгийн 7 алдаа<sup>2</sup> илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан барилга, байгууламж, орон сууцны дүнг, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнгээс 275,246.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Биет бус хөрөнгөд бүртгэлтэй барилгын газрын эзэмших эрхийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэлд залруулга хийхдээ дансны үнийг 9,092.3 мянган төгрөгөөр давхардуулан нэмэгдүүлж тайлагнасан;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет бус хөрөнгийг данснаас хасахдаа хуримтлагдсан элэгдлийг бууруулаагүйгээс хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүн нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дансны үнээс 1,115,335.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн;
- Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд худалдан авсан хөрөнгийн дүн мөнгөн гүйлгээний тайлангийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнгээс 2,247.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн;
- Санхүүгийн тайланд тусгагдсан олон жил болсон 4,900.0 мянган төгрөгийн авлагыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр данснаас хасалт хийсэн;
- Ажилтнуудад илүү тооцож олгосон 1,811.2 мянган төгрөгийн цалингийн авлагыг буцааж авахдаа цалингийн өглөг дансанд бүртгэсэн;
- Үр дүнгийн тайланд тусгагдсан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнг өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн дүнгээс 182,061.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 2,553,225.0 мянган төгрөгийн 14 зөрчил<sup>3</sup> илэрснээс 1,604,263.0 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 948,962.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,553,225.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,952,592.4 мянган төгрөгөөр их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын ангиллыг 274,999.6 мянган төгрөгөөр буруу тайлагнасан. Үүнд: Гэрээт ажилтны цалин, хөлсний зардлаас 3 хуулийн этгээдэд гэрээт ажлын хөлс 38,700.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 77,432.8 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 7 төрлийн сургалт, хэлэлцүүлэг, ахмад настныг хүлээн авахад 49,506.4 мянган төгрөг, тээвэр, шатахууны зардлаас албан томилолтоор ажилласан 124 ажилтны замын зардлын 14,764.0 мянган төгрөг, нормын хувцас хэрэглэлийн зардлаас ахмадуудад монгол дээлийн 29,382.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардлаас ХНХ-ын салбарын 2020-2023 онд хэрэгжүүлсэн бодлого сурталчлах сонины зардалд 19,602.0 мянган төгрөг, ажил, бараа

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үйлчилгээний бусад зардлаас 45,612.4 мянган төгрөгийг гадаад томилолтын зардалд тус тус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын харьяа 2 байгууллагад нийт 166,027.0 мянган төгрөгийн төсвийг шилжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт өсвөр үе, залуучуудад уран сайхны кино үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээнд 54,468.0 мянган төгрөг, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт сурагчдад зориулсан өдөрлөгийн зардалд 111,559.0 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 42 дугаар зүйлийн 42.2.3-т "төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 111,806.6 мянган төгрөгийг бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг нэр төрлөөр бүртгээгүй, шууд зардалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй нэг төрлийн ажил, үйлчилгээг 23 хуулийн этгээдтэй нийт 591,972.3 мянган төгрөгийн ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж

ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.", Засгийн газрын баталсан 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын "шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлалгүй, шууд гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор баталсан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад ороогүй Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргаа удирдлагын дарга нар суудлын автомашинаар үйлчлүүлж, шатахууны зардалд нийт 25,863.3 мянган төгрөгийг зарцуулсан, үүнээс замын тооцооны хуудасгүй 18,984.6 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Засгийн газрын 2022 оны 204 дүгээр "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 7-д "Суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалт", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.", 6.3-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6. Тайлант онд гадаад, дотоод томилолтын 127,084.1 мянган төгрөгийг бараа ажил үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлэх болон бараа үйлчилгээний бусад зардлаас ангилал зөрчин зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох зардлын ангилал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын зардлыг ангилал зөрчин зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

7. Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 9 албан хаагчид 4,791.0 мянган төгрөгөөс 6,906.0 мянган төгрөг хүртэл нийт 50,710.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг /ажлаас чөлөөлөгдөх өргөдөл, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургуулийн тодорхойлолт зэрэг нотлох баримтгүй/ олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

8. Тус яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэх ажлыг 9 иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж нийт 97,800.00 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөө, 16 дугаар зүйлийн "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэх ажлыг иргэн хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

9. Сургалт, хэлэлцүүлгийн арга хэмжээ зохион байгуулахад 7 хуулийн этгээдтэй 2024 оны 5 дугаар сард ажил үйлчилгээ үзүүлэх шууд гэрээ байгуулж, 2024 оны 12 дугаар сард анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйцэтгэсэн үр дүнгийн тайлангүй нийт 123,700.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Зарим аймгуудын ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдоогүй, ажлын тайлан нь цаг хугацааны хувьд зөрүүтэй, 2 хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх шууд гэрээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, нийт 17,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр олгосон.

Тус яам нь Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжтэй "Хүүхэд хамгааллын жишиг бодлого боловсруулах, сургалт зохион байгуулах" ажлыг 16,800.0 мянган 7 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулж, гэрээнд ажил гүйцэтгэх, хүлээлцэх хугацааг тусгаагүй байна. Уг арга хэмжээний гүйцэтгэлийг нягтлахад ямар ажил үйлчилгээ үзүүлсэн нь тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлогдоогүй, баримтын бүрдэл дутуу байхад 2024 оны 9 дүгээр сард 16,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

#### Илрүүлэлт 1:

Тус яам нь 2 удаагийн нийт 92,493.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө." гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бараа материалын орлого, зарцуулалтыг тухай бүрд бүртгэж, хяналт хэрэгжүүлэх албан тушаалтан чиг үүргээ хэрэгжүүлэх.

## 2.Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

### Илрүүлэлт 2:

Тайлант онд 15 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулахад 620,489.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр хоол, цай, усны зардалд 72 хувь буюу 445,906.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сургалт, хэлэлцүүлгийн зардлыг зөв, зохистой зарцуулах.

## 3.Цалин, хөлстэй холбоотой асуудал

### Илрүүлэлт 3:

1.Ажилтнуудын 2024 оны 1-12 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь ХХОАТ-ын тайлангийн дүнгээс 58,313.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 72,833.6 мянган төгрөгөөр тус тус дутуу, нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүн нь татварын тайлангийн цалингийн дүнгээс 14,520.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах," Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх," гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цалин, хөлс болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тайлагнах

## 4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал

### Илрүүлэлт 4:

Байгууллагын лого, брошюр, хэвлэлийн эх бэлтгүүлэхэд 6 иргэнтэй нийт 76,887.3 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс 6,100.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, .... тооцон албан татвар ногдуулна." гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Иргэн, хувь хүнтэй гэрээ байгуулан ажил үйлчилгээ авахдаа хуульд заасан татвар ногдуулах хувиар НӨАТ тооцсон дүнгээр гэрээ байгуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ГБХНХЯ	Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан барилга, байгууламж, орон сууцны дүнг, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнгээс 275,246.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	275,246.1			1	275,246.1	1	275,246.1				
	Биет бус хөрөнгөд бүртгэлтэй барилгын газрын эзэмших эрхийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэлд залруулга хийхдээ дансны үнийг 9,092.3 төгрөгөөр давхардуулан нэмэгдүүлж тайлагнасан.	1	9,092.3			1	9,092.3	1	9,092.3				
	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет бус хөрөнгийг данснаас хасахдаа хуримтлагдсан элэгдлийг бууруулаагүйгээс хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүн нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дансны үнээс 1,115,335.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.	1	1,115,335.1			1	1,115,335.1	1	1,115,335.1				
	Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд худалдан авсан хөрөнгийн дүн мөнгөн гүйлгээний тайлангийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнгээс 2,247.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.	1	2,247.7			1	2,247.7	1	2,247.7				
	Санхүүгийн тайланд тусгагдсан олон жил болсон 4,900.0 мянган төгрөгийн авлагыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр данснаас хасалт хийсэн.	1	4,900.0			1	4,900.0	1	4,900.0				
	Ажилтнуудад илүү тооцож олгосон 1,811.2 мянган төгрөгийн цалингийн авлагыг буцааж авахдаа цалингийн өглөг дансанд бүртгэсэн байна.	1	1,811.2			1	1,811.2	1	1,811.2				
	Үр дүнгийн тайланд тусгагдсан үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнг өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн дүнгээс 182,061.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	182,061.0			1	182,061.0	1	182,061.0				
<b>Дүн</b>		<b>7</b>	<b>1,590,693.4</b>	-	-	<b>7</b>	<b>1,590,693.4</b>	<b>7</b>	<b>1,590,693.4</b>			-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ГБХНХЯ	Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын ангиллыг 274,999.6 мянган төгрөгөөр буруу тайлагнасан. Үүнд: Гэрээт ажилтны цалин, хөлсний зардлаас 3 хуулийн этгээдэд гэрээт ажлын хөлс 38,700.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 77,432.8 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 7 төрлийн сургалт, хэлэлцүүлэг, ахмад настныг хүлээн авахад 49,506.4 мянган төгрөг, тээвэр, шатахууны зардлаас албан томилолтоор ажилласан 124 ажилтны замын зардлын 14,764.0 мянган төгрөг, нормын хувцас хэрэглэлийн зардлаас ахмадуудад монгол дээлийн 29,382.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардлаас ХНХ-ын салбарын 2020-2023 онд хэрэгжүүлсэн бодлого сурталчлах сонины зардалд 19,602.0 мянган төгрөг, ажил, бараа үйлчилгээний бусад зардлаас 45,612.4 мянган төгрөгийг гадаад томилолтын зардалд тус тус зарцуулж эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	274,999.6			1	274,999.6						
	ГБХНХСайдын харьяа 2 байгууллагад нийт 166,027.0 мянган төгрөгийн төсвийг шилжүүлсэн байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт өсвөр үе, залуучуудад уран сайхны кино үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээнд 54,468.0 мянган төгрөг, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт сурагчдад зориулсан өдөрлөгийн зардалд 111,559.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	166,027.0			1	166,027.0						

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 111,806.6 мянган төгрөгийг бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн.	1	111,806.6			1	111,806.6						
Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй нэг төрлийн ажил, үйлчилгээг 23 хуулийн этгээдтэй нийт 591,972.3 мянган төгрөгийн ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон.	1	591,972.3			1	591,972.3						
Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор баталсан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад ороогүй Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргаа удирдлагын дарга нарт "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-тай суудлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан шатахууны зардалд нийт 25,863.3 мянган төгрөгийг зарцуулсан, үүнээс замын тооцооны хуудасгүй 18,984.6 мянган төгрөгийн 4 ажил гүйлгээг бүртгэсэн.	1	25,863.3			1	25,863.3						
Тайлант онд гадаад, дотоод томилолтын 127,084.1 мянган төгрөгийг бараа ажил үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлэх болон бараа үйлчилгээний бусад зардлаас ангилал зөрчин зарцуулсан.	1	127,084.1			1	127,084.1						
Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 9 албан хаагчид 4,791.0-6,906.0 мянган төгрөг хүртэлх нийт 50,710.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг анхан шатны баримт нь хангалтгүй байхад олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	50,710.0			1	50,710.0						
Тус яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэх ажлыг /харьяа байгууллагын бүтэц орон тоог шинэчлэх, хуулийг даган гаргах дүрэм, журмын төслийг боловсруулах, үйл ажиллагааны төсвийг үр дүнтэй төлөвлөх журмын төслийг боловсруулах гэх мэт/ 9 иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж нийт 97,800.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	97,800.0			1	97,800.0						

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>1. Сургалт, хэлэлцүүлгийн арга хэмжээ зохион байгуулахад 7 хуулийн этгээдтэй 2024 оны 5 дугаар сард ажил үйлчилгээ үзүүлэх шууд гэрээ байгуулж, 2024 оны 12 дугаар сард анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйцэтгэсэн үр дүнгийн тайлангүй нийт 123,700.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p> <p>2. Зарим аймгуудын ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдоогүй, ажлын тайлан нь цаг хугацааны хувьд зөрүүтэй, 2 хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх шууд гэрээ 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, нийт 17,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр олгосон.</p> <p>3. Тус яам нь Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжтэй "Хүүхэд хамгааллын жишиг бодлого боловсруулах, сургалт зохион байгуулах" ажлыг 16,800.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулж, гэрээнд ажил гүйцэтгэх, хүлээлцэх хугацааг тусгаагүй байна. Уг арга хэмжээний гүйцэтгэлийг нягтлахад ямар ажил үйлчилгээ үзүүлсэн нь тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлогдоогүй, баримтын бүрдэл дутуу байхад 2024 оны 9 дүгээр сард 16,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.</p>	1	158,000.0							1	158,000.0											
<p>Байгууллагын лого, брошур, хэвлэлийн эх бэлтгүүлэхэд 6 иргэнтэй нийт 76,887.3 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс 6,100.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон.</p>	1	6,100.0												1	6,100.0						

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.Ажилтнуудын 2024 оны 1-12 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь ХХОАТ-ын тайлангийн дүнгээс 58,313.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 72,833.6 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан;	1	116,627.1							1	116,627.1		
2. Нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүн нь татварын тайлангийн цалингийн дүнгээс 14,520.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.												
Тус яам нь 2 удаагийн нийт 92,493.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн.	1	92,493.5							1	92,493.5		
Тайлант онд 15 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулахад 620,489.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр хоол, цай, усны зардалд 72 хувь буюу 445,906.0 мянган төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	445,906.0							1	445,906.0		
Санхүүгийн тайланд тусгагдсан биет бус хөрөнгийн дүн өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн дүнгээс 287,835.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	287,835.4							1	287,835.4		
<b>Дүн</b>	<b>14</b>	<b>2,553,225.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>9</b>	<b>1,604,263.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>948,962.1</b>	<b>-</b>	<b>-</b>

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
ГБХНХЯ	"Засгийн газрын цом-2024" спортын арга хэмжээнд оролцох хураамжийн 4,900.0 мянган төгрөгийг яамны мэргэжилтний хувийн харилцах дансанд анхан шатны баримтгүй шилжүүлсэн, мөн байгууллагын албан хаагчдад хүндэтгэл үзүүлэхэд мөнгөн аяга авахад 5,385.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн чуулганы бэлэг, дурсгалын зүйлд 1,839.0 мянган төгрөг, яамны албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардлаас 747.5 мянган төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	12,871.5			1	12,871.5					
	Байгууллагын шилдэг ажилтнаар шалгарсан 18 албан хаагчид /1,933.0-2,171.0 мянган төгрөг хүртэл/ нийт 37,388.0 мянган төгрөгийн шагналыг зардлын ангилал зөрчин цалингийн зардлаас зарцуулсан.	1	37,388.0			1	37,388.0					
	Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.	1	-								1	-
	Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 4,670,383.8 мянган төгрөгийн 35 гүйлгээг байршуулаагүй байна.	1	4,670,383.8			1	4,670,383.8					
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>4,720,643.3</b>			<b>3</b>	<b>4,720,643.3</b>				<b>1</b>	<b>-</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 288/АД161139  
СНАГ-2025/105/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын ангиллыг 274,999,577.4 /хоёр зуун далан дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга таван зуун далан долоон/ төгрөгөөр буруу тайлагнасан. Үүнд: Гэрээт ажилтны цалин, хөлсний зардлаас 3 хуулийн этгээдэд гэрээт ажлын хөлс 38,700,000.0 /гучин найман сая долоон зуун мянган/ төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 77,432,800.0 /далан долоон сая дөрвөн зуун гучин хоёр мянга найман зуун/ төгрөг, хоол хүнсний зардлаас 7 төрлийн сургалт, хэлэлцүүлэг, ахмад настныг хүлээн авахад 49,506,378.0 /дөчин есөн сая таван зуун зургаан мянган гурван зуун далан найм/ төгрөг, тээвэр, шатахууны зардлаас албан томилолтоор ажилласан 124 ажилтны замын зардлын 14,764,000.0 /арван дөрвөн сая долоон зуун жаран дөрвөн мянган/ төгрөг, нормын хувцас хэрэглэлийн зардлаас ахмадуудад монгол дээлийн 29,381,999.4 /хорин есөн сая гурван зуун наян нэгэн мянга есөн зуун ерэн есөн/ төгрөг, бичиг хэргийн зардлаас хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2020-2023 онд хэрэгжүүлсэн бодлого сурталчлах сонины зардалд 19,602,000.0 /арван есөн сая зургаан зуун хоёр мянган/ төгрөг, ажил, бараа үйлчилгээний бусад зардлаас 45,612,400.0 /дөчин таван сая зургаан зуун арван хоёр сая дөрвөн зуун/ төгрөгийг гадаад томилолтын зардалд тус тус зарцуулж эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 289/АД161139

Улаанбаатар хот

СНАТ-2025/105/НА-СМА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын харьяа 2 байгууллагад нийт 166,027,000.0 /нэг зуун жаран зургаан сая хорин долоон мянган/ төгрөгийн төсвийг шилжүүлсэн байна. Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт өсвөр үе, залуучуудад уран сайхны кино үнэ төлбөргүй үзүүлэх арга хэмжээнд 54,468 000.0 /тавин дөрвөн сая дөрвөн зуун жаран найман мянган/ төгрөг, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт сурагчдад зориулсан өдөрлөгийн зардалд 111,559,000.0 /нэг зуун арван нэгэн сая таван зуун тавин есөн мянган/ төгрөгийг тус тус шилжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 42 дугаар зүйлийн 42.2.3-т "төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 290/А0161139  
СНАТ-2025/05/НА-СНА-ТМ43

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 111,806,639.5 /нэг зуун арван нэгэн сая найман зуун зургаан мянга зургаан зуун гучин есөн/ төгрөгийг бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалыг нэр төрлөөр бүртгээгүй, шууд зардалд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/, аж ахуйн нярав /О.Чадраабал/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264270



АТЛҮА93 9006109  
9027030583

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-53.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 291 /А 016 1139  
СМДТ-2025/105 /НХА-СМА-ТМЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримтлаагүй нэг төрлийн ажил, үйлчилгээг 23 хуулийн этгээдтэй нийт 591,972,295.0 /таван зуун ерэн нэгэн сая есөн зуун далан хоёр мянга хоёр дуун ерэн таван/ төгрөгийн ажил үйлчилгээг шууд гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч өрөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний өрөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.", Засгийн газрын баталсан 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын "шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлалгүй, шууд гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 292/А0161139  
СНАГ-2025/105/АА-СМА-ТММЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолоор баталсан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад ороогүй Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргаа удирдлагын дарга нар суудлын автомашинаар үйлчлүүлж, шатахууны зардалд нийт 25,863,300.0 /хорин таван сая найман зуун жаран гурван мянган гурван зуун/ төгрөгийг зарцуулсан, үүнээс замын тооцооны хуудасгүй 18,984,575.0 /арван найман сая есөн зуун наян дөрвөн мянга таван зуун далан таван/ төгрөгийн 4 ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," Засгийн газрын 2022 оны 204 дүгээр "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 7-д "Суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалт", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.", 6.3-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 293/А016/139  
СНАТ-2025/105/МнА-СТН-ТНЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гадаад, дотоод томилолтын 127,084,122.60 /нэг зуун хорин долоон сая наян дөрвөн мянга нэг зуун хорин хоёр/ төгрөгийг бараа ажил үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлэх болон бараа үйлчилгээний бусад зардлаас ангилал зөрчин зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох зардлын ангилал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан томилолтын зардлыг ангилал зөрчин зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тоируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-53.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 294/АД161139

Улаанбаатар хот

СНАГ-2025/105/Хд-СТН А-ТНУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 9 албан хаагчид 4,791,000.00 төгрөгөөс 6,906,000.00 төгрөг хүртэл нийт 50,710,000.0 /тавин сая долоон зуун арван мянган/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ЭСӨХЖАРГАЛ

ATA9893 1081109  
9023030583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 295 /А0161139  
СНДТ-2025/105/НАСМА-ДММЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэх ажлыг 9 иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж нийт 97,800,000.00 /ерэн долоон сая найман зуун мянган/ төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөө, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу гүйцэтгэх ажлыг иргэн хуулийн этгээдээр гүйцэтгүүлж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
В.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 296/АД/161139  
СНАГ-2025/105/АА - СМ А-ТМУЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сургалт, хэлэлцүүлгийн арга хэмжээ зохион байгуулахад 7 хуулийн этгээдтэй 2024 оны 5 дугаар сард ажил үйлчилгээ үзүүлэх шууд гэрээ байгуулж, 2024 оны 12 дугаар сард анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажил гүйцэтгэсэн үр дүнгийн тайлангүй нийт 123,700,000.0 /нэг зуун хорин гурван сая долоон зуун/ төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2. Зарим аймгуудын ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь анхан шатны баримтаар бүрэн нотлогдоогүй, ажлын тайлан нь цаг хугацааны хувьд зөрүүтэй, 2 хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх шууд гэрээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, нийт 17,500,000.00 /арван долоон сая таван зуун мянган/ төгрөгийн санхүүжилтийг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр олгосон.

3. Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжтэй "Хүүхэд хамгааллын жишиг бодлого боловсруулах, сургалт зохион байгуулах" ажлыг 16,800,000.0 /арван зургаан сая найман зуун мянган/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээг 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулж, гэрээнд ажил гүйцэтгэх, хүлээлцэх хугацааг тусгаагүй байна. Уг арга хэмжээний гүйцэтгэлийг нягтлахад ямар ажил үйлчилгээ үзүүлсэн нь тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлогдоогүй, баримтын бүрдэл дутуу байхад 2024 оны 9 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 297/А0161139

Улаанбаатар хот

СНАТ-2025/105/АА-СМА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Засгийн газрын цом-2024" спортын арга хэмжээнд оролцох хураамжийн 4,900,000.00 /дөрвөн сая есөн зуун мянган/ төгрөгийг яамны мэргэжилтний хувийн харилцах дансанд шилжүүлсэн, байгууллагын албан хаагчдад хүндэтгэл үзүүлэхэд зориулан мөнгөн аяга худалдан авахад 5,385,000.00 /таван сая гурван зуун наян таван/ төгрөг, эмэгтэйчүүдийн чуулганы бэлэг, дурсгалын зүйлд 1,839,000.00 /нэг сая найман зуун гучин есөн мянган/ төгрөг, яамны албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардлаас 747,500.00 /долоон зуун дөчин долоон мянга таван зуун/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хэмнэлтийн бодлогыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ЭСӨХЖАРГАЛ

АУ693 9306109  
9023030583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 298/А0161139

Улаанбаатар хот

СМАГ-2025/105/АА-СНА-ТН 243

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилдэг ажилтнаар шалгарсан 18 албан хаагчид /1,933,000.00 төгрөгөөс 2,171,000.0 төгрөг хүртэл/ нийт 37,388,000.0 /гучин долоон сая гурван зуун наян найман мянга/ төгрөгийн шагналыг зардлын ангилал зөрчин цалингийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"; "Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох ангилал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 299/АД161139

Улаанбаатар хот

СНХТ-2025/105/АЛ-СМА-ТММЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4,670,383.8 /дөрвөн сая зургаан зуун далан мянга гурван зуун наян гурав/ төгрөгийн 35 гүйлгээг байршуулаагүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/, нягтлан бодогч /Г.Ганцэцэг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

  
Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\20250225 SNAG-53.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 300/АД161139  
СМАТ-2025/05/НХ-СМА-ТММЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ;" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Ганцэцэг/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Мөнхзул/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

АТА2623 3006109

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SMAG-53.Docx

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар-15160, Монгол Улс